



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/424

Ховд

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Толхын ойл" ХХК-ийн барьж гүйцэтгэсэн "12 айлын орон сууцны 00 давхарт байрлах № 02, № 03 тоот тус бүрийг үйлчилгээний зориулалтаар үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргах боломжтой хэсэг"-ийг барилгын ажлын зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: А.Жамьяансүрэн - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга, өргөх механизмын хяналтын улсын ахлах байцаагч

С. Батдорж - Архивын тасгийн дарга

Д.Эрдэнэбат - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

Нарийн бичгийн дарга: Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. "Толхын ойл" ХХК-ийн барьж гүйцэтгэсэн "12 айлын орон сууцны 00 давхарт байрлах № 02, № 03 тоот тус бүрийг үйлчилгээний зориулалтаар үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргах боломжтой хэсэг"-ийг барилгын ажлыг зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга /Б.Баярсүх /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Т.Жаргалсайхан

Т. ЖАРГАЛСАЙХАН